Today, the Institute of Archeology, Institute of Paleontology of Mongolian Academy of Science, International Institute for the Study of Nomadic Civilizations, National Museum of Mongolia, Department of Archeology and Anthropology at the School of Social Science, National University of Mongolia, Department of History at Mongolian State University of Education, Department of Archeology at University of Ulaanbaatar and "Chinggis Khaan" university are making legal archeological excavations and research works, and collecting the information for immovable properties.

Historical and cultural immovable properties in protection of state and province: "Protection and Preservation Rule for Historical and Cultural Properties" was adopted by the 79th conference decision of Presidium of State Baga Khural in 1941. At its second appendix, the presidium has decided

to select 15 immovable properties as the first degree state protection, 16 immovable properties as a state protection. After adopting the “Law on Protection of Cultural Properties of People’s Republic Mongolia” in 1970, by the 420th resolution of 1971 by Council of Ministers of Mongolia, has adopted the “List of Protection of Historical and Cultural Heritage of People’s Republic Mongolia”, has selected 21 immovable properties for the state protection, and 106 immovable properties for provincial protection. According to this 420th decision, these immovable properties include statues built for memorial purposes of historical events and individuals, columns, and with tombs, tumulus, ancient settlements, ancient ruins, man stones, deer stones.

“List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised, according to the amendments of “Protection Law of Historical and Cultural Properties” of 1994. At the third appendix of 233rd decision, the Government of Mongolia has decided to select 93 immovable properties as a state protection, 287 immovable properties as a provincial protection, according to the “List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province and city Ulaanbaatar”. The list has specific rules for ancient historical and cultural properties.

In 1995-1997, the State Great Khural amended the “Law of Mongolia on Administrative and Territorial Units and Their Governance”, and established new administrative units. For this reason, the need to change the name of administrative units was required for the “List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province”. Also the number of discovered immovable properties by the science and research organizations were required to be included in the state protection. In 1998, by the 235th decision of Government, the “List of Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised. In accordance with it, 120 immovable properties were selected for the state protection, 233 immovable properties were selected for provincial level protection.

In 2004, the UNESCO World Heritage Committee inscribed Orkhon Valley Cultural Landscape on World Heritage List, including valuable historical and cultural heritages of human history. Orkhon Valley Cultural Landscape has over 100 cultural sites and about 1350 historical and cultural immovable properties, covering area of 121,967 hectares. Orkhon Valley Cultural Landscape has number of immovable properties selected to state and provincial protection.

“The Law for Protection of Historical and Cultural Properties of 1994” has been revised and changed to “the Law for Protection of Cultural Heritage” by the State Great Khural in 2001. As a result of the past 10 years archeological excavations and research works, the number of cultural properties were discovered, and further protection was required for the preservation of those properties. In accordance with it, the “List for Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised by the government in 2008. On May 14th of 2008, the protection list has been revised by the 175th resolution of Government, and 175 immovable properties were selected as the state protection, 275 immovable properties are under province protection. 15 immovable properties are included in the state protection. 40 immovable properties are under the state protection, 57 immovable properties under province protection. And for the first time, paleontological sites were selected in the protection list of the state and province.

Protection zone of immovable properties: In Paragraph 6 of article 16, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994”, “Government has set up 0.1-3 kilometers of protection zone around the historical and cultural immovable properties, such as remains of ancient cities and settlements, buildings, architecture complexes in order to provide the integrity and safety thereof”. In accordance with this article, setting up protection zones around the immovable properties oversaw their significance on history, culture, science and classification on state protection. By the 241st resolution of Government in 1997, first protection zone was set up around ruins of Kharkhorum city, capital of Mongolian Empire, covering an area of 9.69 square kilometers.

The “Protection law of Historical and Cultural Properties of 1994” revised and changed to “Protection law of Cultural Heritage” by the State Great Khural, in 2001. Paragraphs 6, 7, 8 of article 17, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994” re-entered into “Protection Law of Cultural Heritage” and the article for measurement of surrounding areas was removed

- By the 96th decision of 2001, the protection zones were set up around the Gandantegchinlen Khiid monastery, Monastery Geser, Green Palace of Bogd Khaan, Temple of Choijin Lama, Temple of Dambadarjaa, Temple of Dashchoilon (Wooden temples), Apartment of Chin Van Khanddorj.
- By the 71st decision of 2002, protection zones were set up around the inscribed monuments for Bilge Khan, memorial complex of Kültegin in Khashaat soum of Arkhangai province, ruins of Khar Balgas in Khotont soum of Arkhangai province, Tövkhön Monastery in Bat- Öziit soum of Öwörkhongai province, inscriptions monument of Tonyokuk in Bayan soum of Töv province.
- By the 190th decision of 2003, the protection zones were set up around the complex of deer stone called place of Uushgiin Öwör in Burentogtokh soum of Khövsgul province, ruins of Avarga in Delgerkhaan soum of Khentii province, temple of Manzushir in Töv province, 2 stone columns of monastery Dari-Ekh in Baynzürkh district of Ulaanbaatar city.
- By the 126th decision of 2004, the protection zones were set up around the ruins of Baruun Khüree in Kharkhorin soum of Öwörkhongai province, remains of 2 temples of Khögnö Tarni in Rashaant soum of Bulgan province
- By the 70th decision of 2006, protection zones were set up around the inscriptions monument and building remains of Tsogtiin Tsagaan baishin, ruins of Khar Bukh in Dashinchilen soum of Bulgan province
- By the 123rd decision of 2006, the protection zones were set up around the Orkhon Valley Cultural Landscape as inscribed on World Heritage List, in Arkhangai, Öwörkhongai, Bulgan province
- By the 135th decision of 2009, the protection zones were set up around the paleontological sites of Ergeliin Zoon in Khatanbulag soum Dornogobi province, complex monuments of Öngöt in Altanbulag soum Töv aimag, complex monuments of Ikh Khöshööt in Delgerkhaan soum Khentii province, complex monuments Öglögchiin Kherem, Rashaan Khad, Üzüür Tshohio in Batshireet soum of Khentii province, Baldan Bereeven temple and rock paintings in Ömnödelger soum of Khentii province, complex monuments of Dund Jargalant, complex of Tsetsen Khan palaces in Kherlen soum of Khentii province, historic building called “Öndör Khorshoo” (recent Fine Art Museum) in Chingeltei District of city Ulaanbaatar, historical building of Central Committee of People’s Party and People’s Government (recent Museum of the History of Ulaanbaatar)
- By the 101st decision of 2011, the protection zone was set up around the monastery Amar bayasgalant in Baruunbüren soum of Selenge province
- By the ... decision of 2011, the protection zone was set up around the Shoroon Bumbagar of Ulaan kherem in Bayannuur soum of Bulgan province
- By the 104th decision of 2012, protection zones were set up around the Sujigtiin am in mountain Noyon in Bornuur soum of Töv province, Zuramt and Juramtyn am in mountain Noyon in Batsumber soum, complex site of Khünnü noble (Xiongnu) in Balgasan tal in Öndör-Ulaan soum of Arkhangai province

Current status and implementation of works of the protection of historical and cultural immovable properties: Many of our historical and cultural immovable properties have already been destroyed by the human activities and natural and weather decays.

Stone monuments are damaged, cracked, disintegrated by water, wind, chemical substances and bacterial damages, which penetrates pores and capillaries of stone. And natural disaster as a quake, fire, water flood, snow and dust storm has damaged stone monuments. Most of the all immovable properties in Mongolia have damaged by water and component became more porous.

Social factors, such as disrespect to culture, urbanization, economic crisis, sparse population, industrialization, illogical policy, irrational planning, religious issues, wrong conservation and protection, human improper activities are damaging historical and cultural heritages.

Recently, physical damages of immovable properties have increased substantially, due to people’s worship ceremonies. When people worship, they offer and spray milk, butter oil on stones, and wrap

them with silk scarf, which have resulted in destruction of these stone monuments.

Today, social behavior has developed disrespect for historical and cultural heritage, people are making illegal excavations to find profits, that also causes destruction and damage for the immovable properties. Also writing letters or drawing images and symbols on ancient rock inscriptions and rock paintings take place.

Since 1940, Mongolia has been organizing number of research and conservation works on protection of immovable properties. In 1944, monastery Erdene Zuu and temple Amarbaysgalant were conserved and restored. In 1960-1961, temple of Choijin Lama, Green Palace of Bogd Khaan were conserved and restored as well.

In 1971, the “Agency of Academy for Research and Scheme Planning of Historical and Cultural Property” was established in the Central Architectural Institute. In 1973, the “Restoration Laboratory of Historical and Cultural Property” was established under the Ministry of Culture. In 1976, both organizations had united under the name of “Conservation and Restoration Laboratory of Historical and Cultural Property”. Since that time until 1995, the organization have conserved many architectural buildings, such as Erdene Zuu, Amarbaysgalant, Gandantegchinlen, Green Palace of Bogd Khaan, temple of Choijin Lama, complex of Tsetsen Khan palaces, monastery of Khachin Lama, apartment of Chin Van Khanddorj, historic buildings in Altanbulag relevant to the People’s Revolution etc. Also local administrations have built fences, put introduction boards near the immovable properties for protecting them.

Through 1999-2005, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” was implemented, organizing a systematic conservation and preservations of historical and cultural immovable properties.

Within the framework of this project, Center of Cultural heritage and its conservators and specialists have conserved and preserved immovable properties, made copies and replicas of properties for the storage in the state fund, which are of significant historical and scientific value to Mongolians. And in the framework of this project, number of works have been implemented, such as building fences, conserving monastery and temple buildings, setting up lightening arresters etc.

In 2007, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” adopted by the 303rd decision of government, for promoting the immovable properties combined with the infrastructure and tourism, and to build capacity of conservators on cultural heritage conservation. The project is planned to be implemented from 2008 till 2015. The work has started. .

Mongolian government is implementing number of works on protection of historical and cultural immovable properties, but it was being destroyed and damaged by the improper activities of people. To stop and prevent this illegal activities on historical and cultural immovable properties, the support of local people is essential.

In the end, we should always remember that our main priority and responsibility is to respect and protect our historical and cultural heritage and pass it on to the future generations.

ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Дундговь аймгийн товч танилцуулга. Дундговь аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт зүүн талаараа Говьсүмбэр, Дорноговь аймагтай, урд талаараа Өмнөговь аймагтай, баруун талаараа Өвөрхангай аймагтай, хойд талаараа Төв аймагтай тус тус хиллэн 74.7 мян.км² газар нутаг эзлэн оршдог. Аймгийн төв нь Мандалговь хот, Улаанбаатар хотоос 275 км зайтай.

Дундговь аймгийн газар нутаг нь Ардын хувьсгалаас өмнө Халхын Түшээт хан аймагт, 1923 оноос Богд хан уулын аймагт харьяалагдаж байжээ. 1931 оны засаг захиргааны өөрчлөлтөөр Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудын нутагт орсон байна. 1942 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 81 дүгээр хурлын тогтоолоор Дундговь аймгийг байгуулж Өмнөговь аймгаас Буянт-Овоо, Өлзийт, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Хулд, Цогтчандмань, Луус, Гурвансайхан, зэрэг 8 сумдыг, Дорноговь аймгаас Баянжаргалан, Их-Эрээн, Өндөршил, зэрэг 3 сумдыг, Төв аймгаас Гувь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Эрдэнэдалай, Цогт-Овоо, Цагаандэлгэр, Сайнцагаан гэсэн 7 сумдыг салган нийт 18 сумыг харьяалуулжээ.

Өнөөдөр Дундговь аймаг нь Адаацаг, Баянжаргалан, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай гэсэн засаг захиргааны 15 сум, 64 багтай. Тус аймагт халх ястан зонхилсон 58.5 мянган ард иргэд оршин сууж амьдарч байна.

Дундговь аймгийн газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн дундаж температур -22° - -26°С, зуны дундаж температур +18° - +24°С, жилд дунджаар 100-200 мм хур тунадас унадаг. Аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх хувийг говийн бор, хужир, мараалаг хам, цайвар хүрэн, хээрийн хүрэн хөрс зонхилсон ухаа гүвээт талархаг газрын гадарга эзлэнэ. Аймгийн нутагт Онгийн голоос өөр томоохон гол байхгүй боловч орон нутгийн ундрага сайтай рашаан булаг цөөнгүй бий. Дэлгэрхангай, Их, Бага газрын чулуу, Гурвансайхан, Дэл, Дэлгэр зэрэг дундаж өндөртөй уулстай. Түүнчлэн Цагаан суврага, Морин толгойн цав, Өөш манхан, зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай.

Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судалсан тухай тойм. Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрдэм шинжилгээний үүднээс бүртгэн баримтжуулж судлах ажил бусад аймгийг бодвол харьцангуй хожуу эхэлжээ. Энэ ажлын эхлэлийг Монголын ууган археологич Х.Пэрлээ Дэрэн сумын нутаг Тахилын усны сайрын орчимд байх эртний гар урчуудын сууринд хийсэн судалгааны ажлаараа тавьсан байна. Мөн тэрээр уг суурингийн ойролцоо байх хэдэн булшийг бүртгэн, заримыг нь малтан судалж эрдэм шинжилгээний хувьд сонирхолтой эд өлгийн зүйлсийг илрүүлсэн байна.

1951 онд Х.Пэрлээ Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Зүүн Бүрэн ууланд буй тоногдсон 2 булшны үлдцийг малтан судалж тоосго, зээ бадын хээтэй нүүр ваар, тосгуур, нөмрөг ваарны үлдэгдлүүд, ширмэн хонх, улаан шавар савны хагархай, 8 ширхэг зоос зэрэг зүйлсийг олжээ. Эндээс олдсон зоосны эртнийх нь 713-740 оны үед цутгасан Тан улсынх, хожмынх нь 1068-1077 оны үед цутгасан Сүн улсын үеийн зоос байжээ.

1957 онд Х.Пэрлээ Өмнөговь, Дундговь, Өвөрхангай аймгийн нутгаар эртний судлалын хайгуул, бүртгэл хийж явахдаа Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт Харгалын гол (Онгийн гол)-д байх Шаазан хотын үлдэгдлийг үзэж, зарим хэмжилт хийн хотын үлдэгдлийн тойм зургийг үйлджээ. Тэрээр тэндээс олдсон шавар эдлэл болон “Юан улсын” шаазан гэгдэх цийлгэр хөх, ягаан паалантай аяганы хагархай, 1064-1066 он, 1078-1078 оны үед холбогдох 2 ширхэг зоос зэрэг хэрэглэгдэхүүнд тулгуурлан уг хотыг “Юан улсын үеийн хот бололтой” хэмээн үзсэн байна.

1959 онд Зөвлөлтийн эрдэмтэн В.В.Волковын удирдсан судалгааны баг Дундговь аймгийн нутгаар хайгуул судалгааны ажил хийж, аймгийн орон нутаг судлах музейн хүрэл хутга, унжлага, зоос, сумын зэв зэрэг зарим үзмэрүүдийг сонирхон судлаж, хөрш бүс нутгаас олдсон адил төстэй олдворуудтай харьцуулалт хийж, он цагийг тогтоохыг оролдсон байна. Мөн тэрээр Дэлгэрхангай

сумын төвийн нутаг дахь Хаан уул, Мандалговь хотын ойролцоох Бага булаг, Тас уул зэрэг газарт хэд хэдэн булш малтан шинжилж судалгааны эргэлтэнд оруулжээ.

1960 онд Зөвлөлтийн эрдэмтэн А.П.Окладников, Монголын археологич Д.Дорж нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн шинжилгээний ангийнхан Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зургийг илрүүлэн олж бүртгэжээ. Энэхүү дурсгалыг 1960-аад оны сүүлээр Д.Дорж, Зөвлөлтийн эрдэмтэн Э.А.Новгородова нар дахин нягтлан судалж, тус аймгийн Баянжаргалан сумын Цагаан айраг болон Дэлийн Зүүн Билүүн хэмээх газраас илрүүлсэн тамга, тэмдэг, тэмээ болон морь унаж жад барьсан хүн, шувуу, янгир, тэмээ, цэг, гэр зэрэг зургуудтай хамтатган 1975 онд хэвлүүлсэн “Петроглифы Монголии” бүтээлдээ нийтэлжээ. Хожим А.П.Окладников Дэл уулын хадны зургийн зарим дүрслэлийн талаар өөрийн бичсэн “Петроглифы Монголии” номондоо нийтэлсэн байна. Тэрээр Өлзийт сумын хуучин төвийн орчмын нутаг нэгэн хавцлын хаданд дүрсэлсэн шовх чихтэй, өргөн дөрвөлжин хоншоортой, нүд болон хүзүүн дээр нь хоёр дугуй хонхорыг товгороор хүрээлж “алим” мэт дүрсэлсэн бүдүүн хөлтэй, урт сүүлтэй, сэлдийг нь зориуд цохон дүрсэлсэн азарганы зургийг их эртний шинжтэй өвөрмөц зураг хэмээн шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулан, янгир, чоно зэрэг бусад зургийг түүний хажуу завсар зайд хожим дүрсэлсэн хэмээн үзжээ.

1969 онд А.П.Окладников, Монголын археологич Д.Дорж нарын удирдсан МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өндөршил, Гурвансайхан сумын заагт орших Ярх уулын орчмоос хуучин чулуун зэвсгийн үеийн бууцыг илрүүлэн олж судалжээ. Эндээс олдсон дугариг, гурвалжин хэлбэрийн зэвсэг, хусуур, болхи хийцтэй нарийн тал нь хавтгай мэс, гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүд нь Монгол орны тухайн үеийн оршин суугчид өрнө зүгийн доод палеолитын үеийн хүний нэгэн адил чулууг засаж, зэвсэг хийх өөрийн тогтсон арга барилтай байсныг харуулсан баримт болсон байна. Тэдгээр судлаачид Ярх уулын чулуун зэвсгийн бууц нь доод палеолитын үед буюу 300.000-500.000 жилийн тэртээд холбогдохыг шинжлэн тогтоожээ.

1971 онд А.П.Окладников, археологич Д.Дорж нарын удирдсан МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Дундговь аймгийн Хулд, Дэрэн сумдын нутгаар хайгуулын ажил гүйцэтгэж үлдэц, хусуур, ялтас, залтас зэрэг чулуун зэвсгийн олдворууд илрүүлэн олж бүртгэсэн байна. Энэхүү шинжилгээний анги 1972 онд Дундговь аймгийн төв Мандалговь хотоос 60 км зайд орших Ёроол говь хэмээх хотгороос цахиур зэвсэг үйлдэж байсан дархны газар шинээр илрүүлэн олж бүртгэжээ. Мөн 1973 онд Дундговь аймгийн Цахиур толгой, Цагаан худаг, Цагаан Өндөр зэрэг газруудад хайгуул хийж чулуун зэвсгийн үеийн хэд хэдэн бууц сууринг шинээр илрүүлжээ.

1979 онд Зөвлөлтийн эрдэмтэн С.Г.Кляшторный, Монголын судлаач С.Харжубай нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ-ийн Бичээс судлалын анги Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Бичигт хадны руни, перс, монгол, хятад бичээс, тамгануудыг нягтлан шинжилсэн байна.

1980-аад оны эхээр академич А.П.Окладников, археологич Т.Санжмятав нар Бага газрын чулууны Гэр хад хэмээх олон тооны хадны зурагтай дурсгалыг илрүүлэн судалж тэдгээрийн он цагийг неолит ба хүрэл зэвсгийн үеэр тогтоосон байна.

1981 онд археологич Т.Санжмятав Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулуунд дөрвөлжин булш малтаж шавар савны хагархай, алтан бөгж, улаан будагтай малын яс, оюу сувс зэрэг зүйлс олсон бол археологич Д.Наваан Дунд шандны аманд хүннү булш малтан судалж олон сонирхолтой эд өлгийн зүйлс илрүүлэн байна.

1984 онд Зөвлөлтийн эрдэмтэн Л.Л.Викторова, Монголын судлаач Г.Мэнэс нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ-ийн Угсаатны зүйн хээрийн шинжилгээний ангийнхан Дундговь аймгийн ОНС музейд хадгалагдаж байсан 2 хүн чулуун хөшөөг дахин нягтлан үзэж дурсгалын тодорхойлолт бичиж, гар зургийн хамт нийтлүүлсэн байна. Дээрх 2 хүн чулуун хөшөөг археологич Д.Баяр “Монголчуудын чулуун хөрөг” нэгэн сэдэвт бүтээлдээ дахин нягтлан хэвлүүлсэн байна.

1988 онд археологич Т.Санжмятав нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ-ийн Хүрэл, төмрийн түрүү үеийг судлах ангийнхан Дэл уулын 32 хүнтийн булш хэмээн нэрлэгдсэн нэгэн дөрвөлжин булшийг

малтан судалжээ. Уг булшны хашлага чулуун дээр бүжиглэж буй хүмүүс, буга, согоо, шувуу, нум сумтай хүн, хөтлөлцөж яваа эрэгтэй, эмэгтэй хоёр хүн, ан амьтан зэргийг сийлж дүрсэлсэн нь энэ төрлийн дурсгалд төдийлөн тохиолдож байгаагүй онцлогтой байжээ.

1989 онд доктор Д.Цэвээндорж, Унгарын эрдэмтэн И.Эрдейли, Зөвлөлтийн эрдэмтэн П.Б.Коновалов нарын бүрэлдэхүүнтэй Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан “Хүннүгийн дурсгал судлах анги” Бага газрын чулууны Дунд Шандын аманд нэг хүннү булш малтан судалж нумын гичирийн ясан наалт, чагтан тээгтэй бүсний хүрэл арал, хүрэл товруу, хүрэл үзүүрийн чимэг, авсны төмөр чимэглэл, шавар савны хагархай зэрэг эд өлгийн зүйлс илрүүлэн олж, хэвлэн нийтлүүлсэн байна.

1990 онд археологич Д.Наваан Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг Хайрхан, Замбага уулын орчимд бүлэг булшнууд илрүүлэн олж хүннүгийн үеийн хоёр, монголын үед холбогдох гурван булш малтаж сонирхолтой олдворуудыг олсон байна. Мөн тэрээр аймгийн ОНС музейн эрхлэгч Л.Мөнхбаяртай хамтран Сайхан-Овоо сумын Хаалган хадны Хангинах гэдэг газар байсан хадны оршуулгыг малтан судалсан ажээ.

1990-ээд оноос МУИС-ын Түүхийн тэнхимийн багш, профессор Д.Хүүхэнбаатар Өлзийт сумын нутагт орших Дэл ууланд түүхийн салбарын оюутны дадлагыг удирдан явуулж цөөнгүй дурсгалыг илрүүлэн олохын зэрэгцээ өмнө нь илэрч олдсон дурсгалуудыг дахин нягтлан үзэж, руни бичиг, хадны зураг зэрэг хэд хэдэн дурсгалыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж судлаачдын сонорт хүргэжээ. Дэл уулын хадны зургийг МУИС-ийн багш доктор Д.Сүхбаатар, судлаач Э.Жигмэддорж, Б.Батсүрэн нарын зэрэг олон судлаачид тал бүрээс нь нягтлан эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна. Мөн эндээс олдсон руни, хятад бичээсүүдийг доктор Ц.Баттулга нарын судлаачид уншиж нийтлүүлсэн байна.

1996-1999 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд Дундговь аймгийн нутагт ажиллаж олон тооны дурсгалыг давтан болон шинээр бүртгэж, гэрэл зураг, гар зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан байдаг. Тэдний цуглуулсан үл хөдлөх дурсгалтай холбоотой мэдээ баримт, эх хэрэглэгдэхүүн эдүгээ СӨУНБМС-д хадгалагдаж байна.

1997 онд МУИС-ийн багш Ц.Баттулга нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг Говь-Угтаал сумын нутаг Ааргийн хадны салбар Их Бичигт гэх газраас 1 мөр түрэг бичээсийг шинээр илрүүлэн олж, тайлбар сэлтийн хамт нийтлүүлжээ.

2003 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээндорж, эрдэм шинжилгээний ажилтан Н.Батболд нарын бүрэлдэхүүнтэй шинжилгээний анги “BoGuKhaTe” ХХК-ийн дэмжлэгтэйгээр Дэл уулын баруун, зүүн Билүүний хадны зургаас 50 гаруй зургийг хэсэгчлэн хуулбар хийн авч, тайлбар сэлтийн хамт 2005 онд нэгэн сэдэвт ном болгон хэвлүүлсэн байна. Судлаачид Дэл уулын баруун, зүүн Билүүний ан хийж буй буюу анчид морь мал хөтөлсөн хүмүүс, ан амьтны хадны зургийн дүр дүрслэл, зохиомжийн онцлогийг бусад хадны зургуудтай харьцуулан үзэж холбогдох цаг хугацааг хүрэл зэвсгийн үеэс төмөр зэвсгийн үе хүртэлх хугацаанд холбогдуулан үзжээ.

2003-2008 онуудад Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд АНУ-ын Мичиганы Их сургуулийн эрдэмтэдтэй хамтарсан хээрийн шинжилгээний анги Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны орчимд археологийн иж бүрэн судалгааны ажлыг хийж олон тооны дурсгалыг ирүүлэн олж бүртгэсэн байна. Түүнчлэн цөөнгүй булш, хиргисүүрийг малтан судалж онц сонирхолтой олон тооны олдворыг илрүүлэн олж Монголын эртний судлалын сан хөмрөгийг баяжуулжээ.

Бага газрын чулууны орчимд явуулсан археологийн судалгааны ажлын зарим үр дүнгийн талаар доктор Ч.Амартүвшин, Ц.Баттулга, Ц.Амгалантөгс, Б.Жаргалан, П.Хатанбаатар, Г.Галдан, АНУ-ын эрдэмтэн Ж.Врайт, Р.Нельсон, В.Ханичёрч нар тухай бүр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсний зэрэгцээ олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурлуудад сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

Дээрх шинжилгээний ангийнхан Бага газрын чулуунд хийсэн дээрх судалгаагаа нэгтгэн “Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу” хэмээх хамтарсан бүтээл хэвлүүлсэн нь говийн бүс нутагт эртний түүх, соёлын дурсгалыг цогцоор нь судалж палеоантропологи, палеозоологи, палеоботаник, палеэкологи, материал судлал, угсаатан судлалын үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэсэн чухал ач холбогдолтой бүтээл болсон юм.

2008 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн доктор Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Ц.Болорбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний анги Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан сумдын нутаг, дахь “Хараат”, “Хайрхан” хэмээх уул уурхайн ашиглалтын талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж олон тооны дурсгалыг илрүүлэн олсон байна.

2010 онд судлаач Р.Мөнхтулга, С.Хүрэлсүх нарын бүрэлдэхүүнтэй шинжилгээний анги Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг Оюут Овоо дахь “Гольден Погада” ХХК-ны ашиглалтын талбайд авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж нийт 100 гаруй дурсгал илрүүлэн бүртгэжээ.

Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалаас 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлаас батлан гаргасан “улсын хамгаалалтад авах дурсгал”-ын жагсаалтад ямар нэг дурсгал ороогүй байдаг. Харин БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ын улсын хамгаалалтад:

- Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Цогт тайжийн бичээстэй гэрэлт хөшөө ... гэсэн 1 дурсгалыг

орон нутгийн хамгаалалтын жагсаалтад:

- Эрдэнэдалай сумын сүм ... гэсэн дурсгалыг тус тус оруулан баталсан байдаг. Энэ тогтоолд орсон Цогт тайжийн бичээстэй гэрэлт хөшөө нь эдүгээ Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байгаа Дуутын хар чулууны бичээс ажээ.

Дундговь аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1975 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан аймаг сум, хороо, хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад дараах дурсгалыг оруулан баталжээ. Үүнд:

- Эрдэнэдалай сумын Цагаан-Овоо бригадын төв дэх модон дуган, Хөх дуган
- Адаацаг сумын Сүм Хөх бүрдийн чулуун хийдийн нуранхай балгас
- Гурвансайхан сумын Наваан ламын давхар чулуун байшин, Их газрын чулууны агуйн бичиг зураг
- Өлзийт сумын Хөтлийн Түрэгийн хөшөө
- Сайнцагаан сумын Саригийн говийн булш, Номгоны хүн чулуу
- Говь-Угтаал сумын бичигт хадны бичиг
- Хулд сумын Хэвтээ Босоогийн агуй, Хөх чулууны хадны бичиг
- Өндөршил сумын Шар Ханангийн агуй, Хаалгын (чулууны) нүх, Үзүүр цавчирын нүхт хад
- Сайхан-Овоо сумын Харганат хотын болон Ламын хийдийн туйр ... гэсэн дурсгалуудыг хамгаалалтад авсан байна. Энэхүү тогтоол нь анх удаа өөрийн аймгийн нутаг дээрх түүх, соёлын дурсгалуудаа хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн чухал шийдвэр байсан юм.

1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргасны дараа Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор хуучин СнЗ-ийн 1971 оны 420 дугаар тогтоолыг шинэчлэн “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт” нэрээр баталжээ. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улс,

аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д Дундговь аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Өлзийт сумын Билүүт ууланд орших сүг зураг, руни бичиг бүхий хад
- Эрдэнэдалай сумын төвд орших Угтаал сангийн далай хийдийн Цогчин дуган
- Эрдэнэдалай сумын Цагаан-овоо гэдэг газар орших Үнстийн хийдийн Цогчин дуган
- Адаацаг сумын нутагт орших Сүх хөхбүрдийн балгас
- Гурвансайхан сумын Ярх ууланд орших Хуучин чулуун зэвсгийн үеийн бууц ... гэсэн 5 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Луус сумын Хөшөөт гэдэг газар орших хөшөө чулуу
- Өлзийт сумын Дэлийн ууланд орших буган чулуун хөшөө сүг зурагтай хад
- Баянжаргалан сумын Саруулын аманд орших бичигт хад
- Хулд сумын Шарангадын нүхэн гэдэг газар орших монгол бичигтэй агуй
- Дэлгэрцогт сумын Бага газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Баянжаргалан сумын Баянхошууны эмээл толгойд орших хэрмийн туурь
- Дэлгэрцогт сумын Дэлгэрийн ууланд орших Дэлгэрийн хийдийн туурь
- Адаацаг сумын нутагт орших Зуутын хийдийн 2 ширхэг дуган
- Дэлгэрцогт сумын Бага газрын чулуу гэдэг газар орших Модот толгойн сүг зурагтай хад
- Цагаандэлгэр сумын Хөшөөтийн бууцны орчимд орших Түрэгийн үеийн хөшөө
- Говь-Угтаал сумын Их газрын чулууны ард орших бичигт хад
- Өндөршил сумын Нартын хадны Мухарын булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
- Дэлгэрхангай сумын Хархашаатын аманд орших сүг зурагтай хад
- Дэлгэрхангай сумын Онгийн голын эрэгт орших Хошуу хийдийн туурь
- Дэлгэрхангай сумын төвд орших Анхны сургуулийн байшин
- Эрдэнэдалай сумын Өргөн гэдэг газар орших Суудал хад
- Сайхан-овоо сумын нутагт Онгийн голын эрэгт орших Онгийн хийдийн туурь
- Сайхан-овоо сумын нутагт Онгийн голын эрэгт орших Шаазан хотын туурь ... гэсэн 18 дурсгалыг тус тус оруулжээ.

1995-1998 онд УИХ-аас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд хамгаалалтад оруулах шаардлагатай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарч ирсэн байна. Энэ шаардлагыг харгалзан Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад Дундговь аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Адаацаг сумын нутагт орших Сүх Хөхбүрдийн балгас
 - Гурвансайхан сумын Ярх ууланд орших Хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
 - Өлзийт сумын Баруун Билүүт ууланд орших сүг зураг, руни бичиг бүхий хад
 - Эрдэнэдалай сумын төвд орших Угтаал сангийн далай хийдийн Цогчин дуган
 - Эрдэнэдалай сумын Цагаан-овоо гэдэг газар орших Үнстийн хийдийн Цогчин дуган
- ... гэсэн 8 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Адаацаг сумын нутагт орших Зуутын хийдийн 2 ширхэг дуган
- Баянжаргалан сумын Ааргийн хадны Саруулын бичигт хад гэдэг газар буй хадны бичиг
- Баянжаргалан сумын Баянхошууны эмээл толгойд орших хэрмийн туурь
- Говь-Угтаал сумын Их газрын чулууны ард орших бичигт хад

- Дэлгэрхангай сумын Онгийн голын эрэгт орших Хошуу хийдийн туурь
- Дэлгэрхангай сумын Хархашаатын аманд орших сүг зурагтай хад
- Дэлгэрцогт сумын Бага газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны өвөр бэл Их тахилгатын хадны сүг зураг
- Луус сумын Улаан нуурын ард буй Хөшөөт гэдэг газар орших хөшөө чулуу
- Өлзийт сумын Дэлийн ууланд Хамар ус, гучин хоёр хүн хөшөөт гэдэг газар орших сүг зурагтай хад, буган чулуун хөшөө
- Өндөршил сумын Нартын хадны Мухарын булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
- Сайхан-овоо сумын нутагт Онгийн голын эрэгт орших Онгийн хийдийн туурь
- Сайхан-овоо сумын нутагт Онгийн голын эрэгт орших Шаазан хотын туурь
- Хулд сумын Шарангадын нүхэн гэдэг газар орших монгол бичигтэй агуй
- Цагаандэлгэр сумын Шар шороотын бууцны орчимд орших хөшөө чулуу
- Эрдэнэдалай сумын Өргөн гэдэг газар орших Суудал хад ... гэсэн 16 дурсгалыг оруулжээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан шинэчлэн баталсан юм. Дундговь аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын улсын хамгаалалтад:

- Адаацаг сумын нутагт орших Сүм Хөхбүрдийн балгас
- Баянжаргалан сумын Хүрэн духын палеонтологийн дурсгалт газар
- Гурвансайхан сумын Ярх ууланд орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
- Өлзийт сумын Баруун билүүт ууланд орших хадны зураг, түрэг бичээс
- Өлзийт сумын Дэл уулын Хамар ус, Гучин хоёр хүн хөшөөт гэдэг газар орших хадны зураг, буган чулуун хөшөө цогцолбор дурсгал
- Эрдэнэдалай сумын төвд орших Угтаал Сангийн далай хийдийн Цогчин дуган
- Эрдэнэдалай сумын Цагаан-Овоо гэдэг газар орших Үнстийн хийдийн Цогчин дуган ... гэсэн 7 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Адаацаг сумын нутагт орших Зуутын хийдийн 2 ширхэг дуган
- Баянжаргалан сумын Ааргийн хадны Саруулын бичигт хад гэдэг газар орших хадны бичээс
- Баянжаргалан сумын Баянхошууны Эмээл толгойд орших хэрмийн үлдэгдэл
- Говь-Угтаал сумын Их газрын чулууны ард орших хадны бичээс
- Дэлгэрхангай сумын Онгийн голын эрэгт орших Хошуу хийдийн туурь
- Дэлгэрхангай сумын Хархашаатын аманд орших хадны зураг
- Дэлгэрцогт сумын Бага газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны өвөр бэл Их тахилгатын хадны зураг
- Дэлгэрцогт сумын Сөдөтийн амны эхний хадны зураг
- Луус сумын Улааннуурын ард орших Хөшөөт гэдэг газрын хөшөө чулуу
- Өндөршил сумын Нартын хадны Мухарын булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
- Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Онгийн хийдийн туурь
- Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Шаазан хотын туурь
- Хулд сумын Шарангадын нүхэн гэдэг газар орших монгол, төвд бичигтэй агуй
- Цагаандэлгэр сумын Шар шороотын бууцны орчимд орших хөшөө чулуу
- Эрдэнэдалай сумын Өргөн гэдэг газар орших “Суудал хад” гэдэг дөрвөлжин булш ... гэсэн 16 дурсгалыг тус тус хамгаалалтад авчээ.

Сүүлийн жилүүдэд түүх, археологи, угсаатны зүйн судалгаа гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туслалцаа дэмжлэгтэйгээр тогтмолжиж байгаатай холбоотойгоор Дундговь аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалуудыг шинээр илрүүлэх, судалж шинжих ажил өргөжин тэлсээр байна. Энэ

ажлын үр дүнд тус аймгийн нутгаас үнэ цэнэ, ач холбогдол нь бүс нутгийн хэмжээнд үнэлэгдэхээр олон арван дурсгал шинээр олдож төрийн хамгаалалтад орох нь эргэлзээгүй юм.

Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалаас Эрдэнэдалай сумын нутагт орших Угтаал Сангийндалай хийдийн цогчин дуганыг 1989-1991 онд Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газраас сэргээн засварлаж хурал номын үйл ажиллагааг сэргээх боломжтой болгожээ. 2008-2009 онд УИХ-ын гишүүн Р.Раашын дэмжлэг тусалцаатайгаар дээврийн хэсэг, асар хаалгыг дахин сэргээн засаж, дуганы гадуур хайс барьсан байна.

Монгол улсын Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолоор батлагдан гарсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийн 2.11-т Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших Сүм Хөх бүрдийн балгаст консерваци хийж, бэхжүүлж хамгаалахаар, Өлзийт сумын Дэл ууланд орших руни бичгийн дурсгалаас дардас авч Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалахаар, мөн сумын Дэл ууланд орших буган чулуу, сүг зурагтай хадыг дурсгалт газар болгон хамгаалалтад авахаар тус тус оруулсан байна. Дээр дурдсан ажлуудын ихэнх нь хэрэгжсэн боловч зарим нэг ажлуудын төсөв зардал, хүн хүч, цаг хугацааг буруу тооцоолсноос болж хэрэгжиж амжаагүй юм.

Дээрх хөтөлбөрт багтсан Өлзийт сумын нутаг дахь Дэл уулын 32 хүнтийн булшны сийлмэл зураг, түрэг бичээсийн хэв дардсыг 2002, 2003 онд Соёлын өвийн төвийн мэргэжилтэн, судлаачид хэв дардас авсны сацуу Баянжаргалан сумын Саруулын амны монгол бичээсийн хэв дардсыг хамтатган авч Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалсан байна.

Соёлын өвийн төв, Дундговь аймгийн музей, Өлзийт сумын ЗДТГ хамтран “Дэл уул орчмын Соёлын өвийн бүртгэл судалгаа” төслийг 2011 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү ажлын хүрээнд Дэл уул орчмын хадны зураг болон бусад дурсгалыг гэрэл зургийн цомог, баримтат кино, вэб сайтаар дамжуулан олон нийтэд сурталчилахаар төлөвлөж эхний ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

Дээр дурдсан хөтөлбөрийг олон агуулгаар баяжуулан цаашид дэс дараатай үргэлжлүүлэхийн тулд Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор шинээр боловсруулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг батлан гаргасан юм. Энэ хөтөлбөрт Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас ямар нэг дурсгал ороогүй байна.

2010 оны үл хөдлөх дурсгалын тооллого, бүртгэлийн ажлын тухай. Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн хээрийн шинжилгээний баг Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлынхаа хүрээнд 2011 оны 9 дүгээр сарын 9-нөөс 10 дугаар сарын 14-нийг хүртэлх хугацаанд Дундговь аймгийн 15 сумын нутагт ажиллалаа. Бид тус аймгийн нутагт нийт 6500 орчим км зам туулан 293 дурсгалт газрын 5500 гаруй нэгж ширхэг дурсгалыг давтан болон шинээр олж бүртгэн, тэдгээрийг 7474 ширхэг дижитал гэрэл зураг, 180 ширхэг негатив хальсны зураг, 7 гар зураг, 225 минутын дүрс бичлэгээр тус тус баримтжууллаа.

Бид Дундговь аймгийн нутагт ажиллахдаа сум орон нутгийн холбогдох хүмүүстэй хамтран ажиллах замаар бүртгэл мэдээлэл, хадгалалт хамгаалалт, хяналт шалгалтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зарим орон нутгийг судлах танхим, музейд палеолит, неолитын үед холбогдох чулуун зэвсгийн үлдэгдэл, бусад эд өлгийн зүйлсийг хүлээлгэн өгч сан хөмрөгийг нь баяжууллаа.

Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлыг хөдөө орон нутагт зохион байгуулахад дэмжин тусалж хамтран ажилласан Дундговь аймгийн музей, сумдын ИТХ, ЗДТГ, Соёлын төвийн хамт олон, Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, малчид, ард иргэддээ баярласан талархаснаа илэрхийлье.

HISTORICAL AND CULTURAL IMMOVABLE PROPERTIES IN DUNDGOVI PROVINCE

Dundgovi province is located in southeastern part of Mongolia, bordering with Govisumber province to the east, with Dornogovi province to the south, with Övörkhangaï province to the west, with Töv province to the north, covering 74.7 thousand sq kms. Mandalgovi is capital of Dundgovi, located 275 kms from Ulaanbaatar city.

Prior to the People's Revolution, the territory of Dundgovi province was a part of Khalkhiin Tüsheet Khan aimag (province) and since 1923, the province was belonged to the Bogd khan mountain province. With the changes of administration, the province territory has belonged to Ömnögovi, Töv and Dornogovi provinces. By the decision of Presidium of State Baga Khural of 1942, the Dundgovi province was established with 18 soums, including 8 soums from Ömnögovi province such as Buyant-ovoo, Ölziit, Saikhan-ovoo, Delgerkhangai, Khuld, Tsogtchandmani, Luus, Gurvansaikhan, 3 soums from Dornogovi province Bayanjargalan, Ikh-Ereen, Öndörshil, 7 soums from Töv provinces Govi-Ugtaal, Delgertsogt, Deren, Erdenedalai, Tsogt-ovoo, Tsagaandelger and Saintsagaan.

Today Dundgovi province has 64 baghs (smallest administrative unit), 15 soums (small administrative unit) Adaatsag, Bayanjargalan, Gurvansaikhan, Govi-Ugtaal, Delgerkhangai, Delgertsogt, Deren, Luus, Ölziit, Öndörshil, Saintsagaan, Saikhan-ovoo, Khuld, Tsagaandelger, Erdenedalai. It has a population of 58.5 thousand, having predominance of khalkh ethnic groups.

Dundgovi province has an extreme continental climate with long, cold winters and short summers. The average winter temperature falls between -22°C and -26°C. In summer it rises between +18°C and +24°C. The average rainfall can be between 100 mm and 200 mm. Most of the territory is steppe, consisting of brown, light brown, gobiin bor, saline soil, solonchak types of soil. However, Dundgovi province does not have biggest rivers and lakes, it have some minerals springs. Mountains of Delgerkhangai, Stone of Ikh and Baga, Gurvansaikhan, Del Delgerii located in the territory of province. As well as, the province have several natural sites of Tsagaan suvarga, Morin tolgoïn tsav, Öösh mankhan.

Research and registration work on immovable properties of Dundgovi province: Scientific research and examination of historical and cultural properties in Dundgovi province has started relatively late from the other provinces of Mongolia. First research and examination work of this province was carried out in ancient settlement of Takhilyn us in territory of Deren soum by Mongolian first archeologist Kh.Perlee. Archeologist Kh.Perlee has registered several tombs around the settlement and excavated some of them. As a result of excavation, interesting archeological findings were discovered.

In 1951, archeologist Kh. Perlee has excavated remain of 2 looted tombs at mountain of Züün büren in territory of Saintsagaan soum in Dundgovi province and found brick, decorated clay tile, concave side up and down tiles, cast-iron bell, fragment of red clay pot and 8 coins. Casted period of those coins were, early one belong to Tang dynasty 713-740 A.C, latest one belong to Sung dynasty 1068-1077 A.C.

In 1957, when archeologist Kh.Perlee was carrying out archeological examination and registration in territory of Ömnögovi, Dundgovi and Övörkhangaï provinces, he has examined the remain of ancient city Shaazan located around of river Khargal (river Ongi) in territory of Saikhan-ovoo soum of Dundgovi province and made its measurement and structural design. Based on ceramic findings, fragments of Chinese porcelain cup and 2 coins (belong to A.C 1064-1066 and 1078), archeologist has stated that this city might be belong to Yuan dynasty.

In 1959, research team under the guidance of Soviet scholar V.V Volkov has examined some objects of Dundgovi province museum, such as bronze knife, pendant, coin, arrow head and compared with other findings found from neighboring countries and tried to determine the period of those findings. As well as, he has excavated several tombs at mountain Khaan close to center of Delgerkhangai soum, Baga bulag close to city Mandalgovi and mountain Tas.

In 1960, Mongolian and Soviet joint research team under the guidance of Russian scientist A.P

Okladnikov and Mongolian archeologist D.Dorj, have discovered and registered the petroglyphs of mountain Del located at territory of Ölziit soum in Dundgovi province. End of the 1960's, archeologist D.Dorj and Russian scientist E.A.Novgorodova have re-examined that petroglyphs and published in the book "Petroglyphs of Mongolia" in 1975, including with the some symbols, horse or camel rider with spear, bird, wild goat, camel, point, ger depiction discovered from place called Tsagaan airag and Deliin Züün Bilüün in territory of Bayanjargalan soum.

Later, Soviet scientist A.P Okladnikov has published some depictions of petroglyphs of mountain Del in his book "Petroglyphs of Mongolia". In Okladnikov's view the petroglyph of stallion located close to old center of Ölziit soum is very special and ancient belong to Neolithic period, because stallion was depicted with peaky ears, square snout, thick legs, long tail and having 2 round shaped hollow in around of eyes and neck. Other petroglyphs, such as wild goat, wolf were engraved later. Soviet scientist A.P Okladnikov and Mongolian archeologist T.Sanjmyatav have examined the petroglyphs of rock called Ger and determined that these petroglyphs belong to Neolithic period and Bronze Age.

In 1969, survey team for Paleolithic studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition have discovered and examined the Paleolithic settlement around of mountain Yarkh located between border of Öndörshil and Gurvansaikhan soum of Dundgovi province. These round and triangle shaped stone tools including flake, rag of draw-knife, scraper were became evidence of Paleolithic person in territory of Mongolia had similar techniques of making tools with Lower Paleolithic person lived in the Western. Examiners and researchers have examined the Stone Age settlement of mountain Yarkh and determined and registered that this settlement belong to Lower Paleolithic period or 300.000-500.000 BC.

In 1971, survey team for Paleolithic studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition under the guidance Soviet scholar A.P Okladnikov and Mongolian archeologist D.Dorj have carried out archeological examination in territory of Khuld and Deren soums of Dundgovi province and discovered stone tools, such as remains, scraper and flake etc. In 1972, survey team for Paleolithic studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition have discovered craftsman place of Stone Age from place called Yorool gobi 60 kms north of province center Mandalgovi and found Levallois shaped remains, flakes and scrapers. In 1973, survey team for Paleolithic studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition have carried out archeological examination in territory of Tsakhiur tolgoi, Tsagaan khudag, Tsagaan-Öndör soums of Dundgovi province and discovered Stone Age settlements.

In 1979, survey team for inscription studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition including Soviet scholar S.G.Klyashtornoy and Mongolist scholar S.Kharjubai have examined Runic, Arabic, Chinese inscriptions and symbols in Erdenedalai soum of Dundgovi province.

Beginning of 1980's, academician A.P Okladnikov and archeologist T.Sanjmyatav have discovered and examined the site called Ger khad with number of petroglyphs. They have decided that these petroglyphs belong to Neolithic and Bronze Age.

In 1981, archeologist T.Sanjmyatav has carried out archeological excavation in square tomb at Stone of Baga gazar in Delgertsogt soum of province and found fragments of ceramic pot, gold ring, animal bone with red paint and turquoise. In addition, archeologist D.Navaan has excavated Xiongnu tomb and found human remains and number of interesting findings.

